

**ЭРҮҮЛ МЭНД, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2009 оны 9 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 283/207



Улаанбаатар
хот

Зөв хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих Үндэсний
стратеги батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 239 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх
зорилгоор ТУШААХ НЬ:

1. Халдварт бус өвчний нийтлэг эрсдэлт хүчин зүйлийг бууруулах “Зөв
хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих Үндэсний стратеги”-ийг нэгдүгээр,
үндэсний стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар
хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд Олон улсын байгууллага,
хандивлагчдын зээл, тусlamжийн тодорхой хэсгийг чиглүүлэхийг Эрүүл мэнд,
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд нарт, стратегийн зорилтыг
хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжилтийг
зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/C.Төгсдэлгэр/, ХХААХҮЯ-ны Хүнсний
үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
/Ч.Энх-Амгалан/, шаардагдаа зардлыг Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайдын багц дахь төвлөрсөн арга хэмжээний зардалд тусгах замаар
санхүүжүүлэхийг ЭМЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газар/Н.Түмэндэмбэрээ/,
ХХААХҮЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газар/П.Баянмөнх/-т тус тус үүрэг
болгосугай.



Танилцуулга

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 15.15 дахь заалтыг үндэслэн хүн амд эрүүл аж төрөх хөв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх ажлыг сайжруулах зорилгоор “Зөв хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн төслийг боловсрууллаа.

Сүүлийн 15 жилийн турш хамгийн бага өртөг зардлаар урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой, хоол, хүнсний хэрэглээ, хөдөлгөөний хомдолтой холбоотой халдварт бус өвчиний улмаас нас бааралтын шалтгаанд зүрх судасны өвчин, чихрийн шижин, ясны сийрэгжилт, хавдар болон эдгээр өвчиний нөхцөлдүүлэгч завсрын хүчин зүйл болох таргалалт, цусны дараалт ихсэлт, цусан дахь өөх тос, сахарын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал: Монгол Улсын хүн амын нас бааралтын тэргүүлэх 5 шалтгааныг 10 000 хүн амд ногдох байдлаар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, бэртэл хордлого гадны шалтгаант үр дагавар, хоол шингээх эрхтний өвчин болон амьсгалын тогтолцооны эмгэг эзэлж байгаа бөгөөд цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 15-45 насныхны дунд түгээмэл байна. Судалгааны дүнгээс харахад хүүхэд, ёсвөр үеийнхний 80,2 хувь нь тухайн насныхаа бие бялдрын хөгжлийн түвшинд хүрэхгүй, 15-34 насны хүн амын бие бялдрын хөгжлийн үзүүлэлт 35-64 насны бүлгийн үзүүлэлтийн дундаж түвшингээс доогуур, 15-64 насны хүн амын 31,6 хувь нь илүүдэл жин ба таргалалттай байгаа нь анхаарал татсан асуудлын нэг болоод байна.

Хүн амын жимс, ногооны хэрэглээ 3.2 нэгж буюу Дэлхийн эрүүл мэндийн байгууллага/ДЭМБ/-ын зөвлөмж болгож буй хэмжээ (5 нэгж буюу 400.0 гр)-нд хүрэхгүй, ялангуяа хөдөөгийн хүн амын хэрэглээ туйлын хангалтгүй, хүн амын 70 орчим хувь нь давстай цай хэрэглэдэг, ДЭМБ-ын зөвлөмж (хоногт 6гр) хэмжээнээс их, түүнчлэн хүн амын 35 орчим хувь нь өөх тосны хэрэглээ өндөр байгаа нь Монгол хүний хоногт хэрэглэвэл зохих зөвлөмж хэмжээнээс их, нийт өөх тосны хэрэглээний 56-81 хувийг амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээс авч байгаа нь тогтоогдсон. Халдварт бус өвчинд нөлөөлж буй эдгээр эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлж, тархалтыг бууруулж чадвал дээрх халдварт бус өвчинөөр өвчлөх, цагаас өмнө нас барах, тахир дутуу болох тохиолдлыг 50 хүртэл хувиар бууруулж нийгэм, эдийн засагт үзүүлж буй дарамтыг бууруулах бүрэн боломжтойг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага зөвлөдөг.

Стратегийг салбарын байгууллагуудын болон салбар дундын хамтын ажиллагаа, бизнес, аж ахуйн нэгж байгууллагын оролцоо, идэвх санаачлагыг өрнүүлэх замаар хэрэгжүүлэх бөгөөд энэхүү стратегийг хэрэгжүүлэх гол салбар нь Эрүүл мэнд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам юм.

Иймээс Засгийн газрын 2009 оны 239 дүгээр тогтоолоор сайшаасан “Зөв хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хамтран батлахаар хүргүүлж байна.

Эрүүл мэндийн яам

Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн 283/207 тоот хамтарсан тушаалтын нэгдүгээр хавсралт

Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги Нэг. Үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын тооцоолсоор Халдварт бус өвчин дэлхийн хүн амын өвчлөлийн 43 хувь, нас бааралтын шалтгааны 60 хувийг эзэлж байгаа бөгөөд 2020 он гэхэд өвчлөлийн 60 хувь, нас бааралтын шалтгаан 73 хувьд хүрэх магадлалтай хэмээн мэдэгдсэн. Халдварт бус өвчин(ХБӨ)-д нөлөөлж байгаа 10 эрсдэлт хүчин зүйлээс хамгийн түгээмэл анхдагч эрсдэлт хүчин зүйлс нь хоол хүнсний зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ болж байгаа бөгөөд эдгээр нь илүүдэл жин, артерийн даралт ихсэлт, цусан дахь өөх тос, сахарын хэмжээ нэмэгдэх зэрэг завсрлын хүчин зүйл байдааар илэрч улмаар өвчлөл, нас бааралтад хүргэдэг. Эдгээрийн 5–6 хүчин зүйл нь хүнсний хэрэглээ ба хөдөлгөөний идэвхтэй нягт холбоотой байна.

Эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлж, тархалтыг бууруулах замаар ХБӨ-өөр өвчлөх, цагаас өмнө нас барах, тахир дутуу болох тохиолдлыг 50 хүртэл хувиар өөрөөр хэлбэл хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгон хэрэглэж, архины хэрэглээг багасган, тамхинаас татгалзан биеийн жингээ хэвийн хэмжээнд барьж, амьдралынхаа туршид биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг эрхэмлэж чадвал зүрх судасны өвчнийг 80 хувь, 2-р хэлбэрийн чихрийн шижинг 90 хүртэл хувиар, хавдрын тохиолдлыг 30 гаруй хувиар бууруулж болно. Өөх тос, чихэр, давсыг хэтрүүлэн хэрэглэснээр артерийн даралт, цусан дахь холестерин, сахарын хэмжээг ихэсгэж, ходоод гэдэсний хорт хавдрын 19 хувь, зүрхний цус хомсдлын 31 хувь нь жимс, хүнсний ногооны бага хэрэглээтэй холбоотой гэж ДЭМБ зөвлөдөг¹.

Монгол Улсын хүн амын нас бааралтын тэргүүлэх 5 шалтгааныг 10 000 хүн амд ногдох байдааар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 21.9, хавдар 12.2, бэртэл, хордлого, гадны шалтгаант үр дагавар 11.7, хоол шингээх эрхтний өвчин 5.5, амьсгалын тогтолцооны эмгэг 2.3 промилийг тус тус эзэлж, хүн амын нас бааралтын шалтгааны дотор сүүлийн 10 гаруй жилд халдварт бус өвчин (ХБӨ) давамгайлж, тасралтгүй нэмэгдэх хандлагатай байна². Хүн амын 61.0 хувь нь нийслэл хот болон аймгийн төвд амьдарч байгаа бөгөөд хүн амын 28.9 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 67 хувь нь 15-64 насныхан, 4.1 хувь нь 65 ба түүнээс дээш насны хүмүүс байна³. Гэвч судалгаагаар хүүхэд, өсвөр үеийнхний 80.2 хувь нь С буюу түүнээс доош үнэлгээтэй, өөрөөр хэлбэл тухайн насныхаа бие бялдрын хөгжлийн түвшинд хүрэхгүй, 15-34 насны хүн амын бие бялдрын хөгжлийн үзүүлэлт 35-64 насны бүлгийн үзүүлэлтийн дундаж түвшингээс доогур, чихрийн шижин өвчний тархалт Монгол Улсын хүн амын дунд жил ирэх тутам нэмэгдэж 8.2 хувьд хүрсэн³. Мөн хүн амын эрүүл мэндийн статистик судалгаанаас хараад цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл 15-45

¹ Эрсдлийг бууруулж, амьдралын эрүүл хэв маягийг дэмжицгээ, Дэлхийн эрүүл мэндийн илтгэл, ДЭМБ, 2002.

² Эрүүл мэндийн статистикийн үзүүлэлт, 2007 он

³ ХБС-ний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын түвшин тогтоо судалгаа, ЭМЯ/ДЭМБ, 2006 он

насныхны дунд түгээмэл байна.

ДЭМБ-ЫН ЗӨВЛӨМЖӨӨР ӨГӨГДСӨН ХЭМЖЭЭНЭЭС ХҮН АМЫН ЖИМС, ХҮНСНИЙ НОГООНЫ ХЭРЭГЛЭЭ БАГА, ДАВС, ӨӨХ ТОСНЫ ХЭРЭГЛЭЭ ИХ БАЙНА.

Монгол Улс хүн амын жимс, хүнсний ногооны хэрэгцээний 50-70 орчим хувийг импортоор хангадаг бөгөөд импортын жимс, зарим хүнсний ногооны үнэ өндөр, экологийн цэвэр, аюулгүй жимс, хүнсний ногооны хангамж, хүртээмж дутмаг байна.

Хүн амын 72.5 хувь нь өдөрт 3.2 нэгж жимс, хүнсний ногоо хэрэглэж, ДЭМБ-ын зөвлөмж болгож буй хэмжээ (5 нэгж буюу 400.0 гр)-нд хүрэхгүй байна. Ялангуяа хөдөөгийн хүн амын жимс, хүнсний ногооны хэрэглээ туйлын хангалтгүй байгаа төдийгүй хүн амын 70 орчим хувь нь давстай цай хэрэглэж байна. Насанд хүрсэн хүн хоногт дунджаар 10.0 грамм давс хэрэглэж байгаа нь ДЭМБ-ын зөвлөмжөөр өгөгдсөн (хоногт 6 гр) хэмжээнээс их байна². Түүнчлэн хүн амын 35 орчим хувь нь өөх тосны хэрэглээ өндөр, хот суурин ба хөдөөд хоногт 92.1 ба 112.5 гр өөх тос хэрэглэж байгаа нь Монгол хүний хоногт хэрэглэвэл зохих зөвлөмж хэмжээнээс их, нийт өөх тосны хэрэглээний 56–81 хувийг амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээс авч байгаа нь тогтоогджээ⁴.

Хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин хижээл насныхнаас доогуур байна.

Хүн амын 15-34 насныхны бие бялдрын хөгжлийн үзүүлэлт 35-64 насныхнаас доогуур, эрэгтэйчүүдийн бие бялдрын хөгжлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс бага, ялангуяа 15-34 насны эрэгтэйчүүдийн 87.7-89.1 хувь нь хөдөлгөөний идэвх багатай, бие бялдрын хөгжил-чийрэгжилтийн байвал зохих түвшинд хүрэхгүй байгаа нь анхаарал татаж байгаа юм². Сүүлийн жилүүдэд цэргийн насны залуучууд бие бялдрын хөгжлийн үзүүлэлтээр цэргийн албандаа тэнцэхгүй байгаа бөгөөд 2008 оны байдлаар тэдний 44.4 хувь энэ үзүүлэлтээр тэнцээгүй байна.

Монгол Улсын 15–64 насны хүн амын 31.6 хувь нь илүүдэл жин ба таргалалттай, үүнээс 21.8 хувь нь илүүдэл жинтэй, 9.8 хувь нь таргалалттай байна. Илүүдэл жин (25.54%) ба таргалалттай (12.5%) эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс (Илүүдэл жин 18.24%, таргалалт 7.22%) харьцангуй өндөр, 15 – 64 насны хүн амын 23.1 (± 0.1) хувь нь биеийн хүч бага шаардсан хөдөлгөөн хийдэг буюу хөдөлгөөний хомдолтой, 34.1 (± 0.05) хувь нь ажлын байр, 29.8 (± 0.1) хувь чөлөөт цагаараа биеийн хүч их болон дунд зэрэг шаардсан хөдөлгөөн хийдэггүй байна². Түүнчлэн 10 хүн тутмын 6 нь (60.5%) бие бялдрын боловсрол, дасгал хөдөлгөөний талаар зохих мэдлэггүй, тэдгээрийн 51% дасгал хөдөлгөөний ач холбогдлыг ойлгодоггүй, 50% эрүүл мэндийн дэмжих биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг их спортоос ялгадаггүй, 57 % нь дасгал хөдөлгөөн, биеийн тамирын дасгалаар хичээллэх орчин нөхцөл муу, энэ талаарх биеийн тамирын арга зүйч багш нарын мэдлэг 51.5 %-д нь хангалтгүй байна⁵.

Хүн амын дунд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалт их байна.

ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 2005 онд Монгол Улсад хийсэн “Халдварт бус

⁴ Хүн амын хоол тэжээл, үндэсний хоёрдугаар судалгааны тайлан, ЭМЯ/НУБХС, Эдмон ХК, 2000 он

⁵ Социологийн судалгаа, БТСУХ, 2005 он.

өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын түвшин тогтоох шатчилсан судалгаа"- аар 15- 64 насны хүн амын 10 хүн тутмын есөд нь (90.6%) ХБӨ-ний нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн аль нэг нь илэрсэн, 5 хүн тутмын (20.7%) нэгдэг З ба түүнээс олон эрсдэлт хүчин зүйлс хавсрал тохиолдож, 45 ба түүнээс дээш насны 2 эрэгтэй хүн тутмын нэг нь ХБӨ-өөр өвчлөх эрсдэл өндөр байгаа нь хүнсний зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний хомсдол нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болж байгааг харуулж байна.

Монгол Улсын хүн амын дунд соёл иргэншил, амьдралын хэв маягтай холбоотой ХБӨ-ний өвчлөл, нас баралт, түүнийг нөхцөлдүүлэгч эрсдэлт хүчин зүйлийн тархалт нэмэгдэж, эрүүл мэндийн эдийн засагт давхар дарамт учруулж байна. Бага өртөг зардлаар урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой ХБӨ-ний гол эрсдэлт хүчин зүйлс болж буй хүнсний зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний хомсдлыг нэгдсэн бодлого, зохицуулалтаар ханганд тархалтыг бууруулах боломжтой.

Иймээс Засгийн газрын 2005 оны 72 дугаар тогтооолоор батлагдсан "Эрүүл мэндийн салбарын 2006-2015 оны мастер төлөвлөгөө"-ний зорилт, стратеги, Монгол улсын Засгийн газраас "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор "Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги"-ийг боловсруулав.

Хоёр . Зорилго

"Хувь хүн, хамт олон, байгууллага, үндэсний түвшинд хүнсний зохистой хэрэглээ, нийтийн биеийн тамирыг дэмжсэн тогтвортой үйл ажиллагаа явуулах орчинг бүрдүүлэх замаар хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах"

Гурав. Үндэсний стратегийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1 Нотолгоонд тулгуурласан арга хэмжээг нийгмийн бүлгүүд, нас, хүйсний онцлогт тулгуурлан явуулах;

4.2 Үндэсний уламжлалт соёл, ёс заншил, зан үйл болон дэвшилтэт арга технологид тулгуурлах;

4.3 Төрийн болон төрийн бус байгууллага, нийгмийн бусад бүлгүүдийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг өргөтгэх.

Дөрөв. Стратегийг хэрэгжүүлэх хугацаа

Стратегийг 2010-2021 он дуустал 12 жилийн хугацаатай хэрэгжүүлнэ. Дунд хугацааны үнэлгээ 2015 онд хийгдэнэ.

Тав. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратегийн зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн:

Стратегийн зорилт 1.

5.1. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжсэн орчин бүрдүүлнэ.

Нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх арга зам:

- 5.1.1. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих талаарх холбогдох хууль тогтоомж, стандарт, удирдамж, заавар, журмыг хянан шинэчилж боловсронгуй болгох;
- 5.1.2. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг үнэ, татварын бодлогоор дэмжих механизм бүрдүүлэх;

- 5.1.3. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжсэн үйлчилгээг хүн амд үзүүлж байгаа байгууллагуудыг Эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулах механизм бүрдүүлэх;
- 5.1.4. Хүнсний бүтээгдэхүүний тэжээллэг чанар, аюулгүй байдал, илчлэгийн хяналт, шошгын стандартын шаардлагыг хангах, биеийн тамирыг дэмжсэн байгууллагуудын ажлын уялдаа, оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах орчин бүрдүүлэх;
- 5.1.5. Орон нутгийн хөгжлийн бодлогод иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх, явган болон дугуйгаар явах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчих тохиромжтой, аюулгүй зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ашиглалтыг сайжруулах, тохижуулахыг дэмжих;
- 5.1.6. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжихэд эрүүл мэнд, биеийн тамир, боловсрол, зам тээвэр, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлаал, хот байгуулалт, мэргэжлийн хяналт зэрэг нийгмийн бусад салбарын хамтын ажиллагааг чиглүүлж, оролцоог нэмэгдүүлэх;
- 5.1.7. Нийтийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний газар, бялдаржуулах, чийрэгжүүлэх төв, клубийн үйл ажиллагааны удирдамж, байр талбайн стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, үйлчилгээний чанарыг сайжруулах;
- 5.1.8. Бие бялдрыг хөгжүүлэх, Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж буй байгууллага, иргэнийг урамшуулах, үйл ажиллагааг нь сурталчилах;
- 5.1.9. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжихэд иргэний нийгмийн болон олон улсын байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн олон нийтийг оролцуулсан кампанит ажлыг өрнүүлэх;
- 5.1.10. Иргэд, хамт олон, олон нийтийн байгууллагууд биеийн тамир, спортоор хичээллэх гүйлт, алхалтын зам, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх ногоон байгууламж бүхий ил талбай, өвлийн улиралд байгалийн болон хиймэл мөс, цасан талбайг орон сууц, гэр хорооллын орчимд байгуулах үйл ажиллагааг дэмжих;
- 5.1.11. Эрүүл мэнд, биеийн тамирын анхан шатны болон хоёрдогч шатлалын байгууллагуудад зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих тогтвортой бүтэц, чадварлаг хүний нөөцтэй болох;
- 5.1.12. Эрүүл мэнд, биеийн тамирын байгууллагуудад үйлчлүүлэгчийн хоол тэжээлийн байдал, хөдөлгөөний идэвхийг хянах, үнэлэх багаж хэрэгслийн хангамж, дотоодын үйлдвэрлэлийг сайжруулах;
- 5.1.13. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих стратегийн хэрэгжилтэнд олон улсын байгууллагын хандив, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, бусад холбогдох үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдааг сайжруулах.

Хүрэх үр дүн:

Хүн ам зөв хооллох, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх материаллаг болон эрх зүй, үйл ажиллагааны таатай орчин бүрдсэн байна.

Стратегийн зорилт 2.

- 5.2. Зөв хооллох, дасгал хөдөлгөөний тусlamжтайгаар эрүүл аж төрөх хэв маягийг хүүхэд ахуй наснаас эхлэн төлөвшүүлж, хүн амын өдөр тутмын хэрэглээ болгоно.

Хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх арга зам:

- 5.2.1. Хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллох бодлогын хэрэгжилтийг сайжруулах;
- 5.2.2. Бүх шатны боловсролын байгууллагын “Биеийн тамир-эрүүл мэнд”,

- “Эрүүл мэнд” хичээлийн агуулга, стандарт, сурах бичгийг шинэчлэх, дадал эзэмших сургалтын орчинг сайжруулах;
- 5.2.3. Бүх шатны боловсролын байгууллагын чөлөөт цаг, хичээлийн бус цагаараа бие бялдраа чийрэгжүүлэх, биеийн тамираар хичээллэх нөхцөл бололцоог сайжруулж, мэргэжил арга зүйн удирдамжаар хангах;
- 5.2.4. Бүх шатны боловсролын байгууллагад зөв хооллох, дасгал хөдөлгөөний талаар сургалт явуулах сургагч багш, эцэг эх, нийгмийн ажилтны мэдлэг, чадварыг сайжруулах;
- 5.2.5. Бүх шатны боловсролын байгууллагын хоол, цайны газар, биеийн тамирын заал, ил талбайн стандартыг шинэчлэх, ашиглалтыг сайжруулах;
- 5.2.6. Бүх шатны боловсролын байгууллагын хоолны газар, хүнсний цэгүүдийн багаж төхөөрөмжийн стандартыг шинэчилэх, хангамж, ашиглалтыг сайжруулах;
- 5.2.7. Эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэгийг хөгжүүлэх, загвар “Эрүүл мэнд”-ийн хичээлийн кабинет, биеийн тамирын заал, хоол цайны газрыг байгуулж, үйл ажиллагааг нь сурталчилан өргөжүүлэх;
- 5.2.8. ЕБС, цэцэрлэгийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хоол, хүнсний тэжээллэг чанар, ундны усны хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах;
- 5.2.9. Бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын заал, талбай, танхим, хоолны газар, хүнсний цэгүүдийн багаж тоног төхөөрөмж, үйл ажиллагааны өнөөгийн байдалд үнэлгээ өгч, хүүхдийн хэрэгцээнд нийцүүлсэн стандартыг бий болгох;
- 5.2.10. Бүх шатны боловсролын байгууллагад хоол, хүнсний зохистой хэрэглээний “Ногоон жор” хөдөлгөөн өрнүүлэх;
- 5.2.11. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эцэг, эхчүүдийн эрүүл хоол, хүнс бэлтгэх, хэрэглэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх мэдлэг, дадлыг сайжруулах.

Хүрэх үр дүн:

Бүх шатны боловсролын байгууллагад зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих орчин бүрдэж, хүн амын энэ талаарх мэдлэг, хандлага, дадал сайжирсан байна.

Стратегийн зорилт 3.

- 5.3. Хувь хүнд зөв зан үйл, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны чанар, хүртээмжийг сайжруулна.**

Гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэх арга зам:

- 5.3.1. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр сургалт явуулах эмч, арга зүйч, сайн дурын идэвхтэнд зориулсан гарын авлага, удирдамж боловсруулж, тэдний мэдлэг, ур чадвар, мэргэшлийг дээшлүүлэх;
- 5.3.2. Олон нийтэд хүргэх цогц цэгцтэй мэдээлэл, агуулгын нэгдэл бүхий сургалт, сурталчилгаа, мэдээллийн нэгдсэн санг эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудад байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулах;
- 5.3.3. Хүн амын нас, хүйс, ажил, гэр бүл, амьдралын онцлог, өвөрмөц хэрэгцээнд тохирсон хоол хүнсний зохистой хэрэглээ, биеийн тамир, дасгал хөдөлгөөний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны цогц материалыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрийн онцлогт нийцүүлэн боловсруулах;
- 5.3.4. Эрүүл мэнд, биеийн тамир, чийрэгжилт, хоол зүйн чиглэлээр ажиллаж буй байгууллагуудын сургалт, сурталчилгааны тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах;

- 5.3.5. Хүн ам эрүүл аж төрөх, зөв зан үйлд суралцах бодит, шинэлэг, үндэслэлтэй мэдээллийг түргэн, шуурхай авч ашиглах боломжийг бүрдүүлэх;
- 5.3.6. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж байгаа эрүүл аж төрөх, зөв зан үйлтэй холбоотой мэдээний чанар, төрөл, хүртээмжийг сайжруулж, хувийн жинг нэмэгдүүлэх;
- 5.3.7. Хүн амын зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, энэ төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг дэмжих;
- 5.3.8. “30 минут өөртөө зарцуулья”, “өдөрт 10 000 алхам алхая” болон аэробик, нийтийн бүжиг, явган аялал, гүйлт, хийн болон йогийн дасгал зэрэг бүх нийтийг хамарсан арга хэмжээг өргөжүүлэх;
- 5.3.9. Хүнсний зохистой хэрэглээ, дасгал хөдөлгөөнийг эрхэмлэн амьдралын эрүүл хэв маягтай үлгэр жишиг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагыг сурталчлах, тэдний туршлагыг олон нийтийн хүртээл болгох, бусад орны туршлагаас суралцах боломжийг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн:

Хүн амын зөв хооллох, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх талаарх мэдлэг, хандлага сайжирч, тэдний эрүүл зан үйл, аж төрөх арга барил сайжирсан байна.

Стратегийн зорилт 4.

- 5.4. Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих тандалтын тогтолцоог бэхжүүлнэ.

Дөрөвдүгээр зорилтыг хэрэгжүүлэх арга зам:

- 5.4.1. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшинг тандах мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;
- 5.4.2. Зөв хооллох, дасгал хөдөлгөөний талаарх судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжин хөгжүүлэх замаар нотолгоонд сууринсан удирдлага, арга зүйн дэмжлэгийг хөгжүүлэх;
- 5.4.3. Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний одоогийн байдалд үнэлгээ өгөх, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;
- 5.4.4. “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн хэрэгжилт, үнэлгээнд олон нийтийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оруулж хэвшигүүлэх;
- 5.4.5. “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулах.

Хүрэх үр дүн:

Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих нотолгоонд сууринсан удирдлага, арга зүйн дэмжлэгт орчин бүрдэж, стратегийн хэрэгжилт сайжирна.

Зургаа. Үндэсний стратегийг хэрэгжүүлэгч талуудын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд бусад салбар, байгууллага, аж ахуйн нэгж болон олон улсын байгууллагын дэмжлэг, оролцоо, хамтын ажиллагааг үндэсний түвшинд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн дэргэдэх эрүүл мэндийн салбарын ажлын бүлэг, орон нутагт Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл зохицуулна.

Стратегийн хэрэгжилтийг зохицуулах ажлын албаны үүргийг ЭМЯ,

ХХААХҮЯ-ны тухайн асуудлыг хариуцсан нэгжийн хамтарсан “Техникийн ажлын хэсэг” гүйцэтгэж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөг холбогдох мэргэжлийн агентлагууд хариуцан хэрэгжүүлнэ. ЭМЯ, ХХААХҮЯ стратегийг хэрэгжүүлэх удирдлага, төлөвлөлтөөр ханган, хэрэгжилтийн явц, үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн салбарын ажлын бүлэгт 2 жилд нэг удаа тайлагнана.

Стратегийн зорилт, үйл ажиллагааны санхүүжилт улсын төсөв, эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө, гадаад, дотоодын төрийн болон төрийн байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусlamж болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Долоо. Үндэсний стратегийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт

Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг үе шаттайгаар явуулж, холбогдох байгууллагад эргэн мэдээлж, олон нийтэд өргөнөөр сурталчилна. Стратегийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг орон нутагт аймаг, нийслэлийн холбогдох агентлагууд хамтран хийж, үндэсний хэмжээнд ЭМЯ, ХХААХҮЯ зохион байгуулна.

Стратегийн хэрэгжилтийн дунд шатны үнэлгээг 2015, эцсийн шатны үнэлгээг 2020 оны дөрөвдүгээр улиралд багтаан хийж, Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Стратегийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Үзүүлэлт	Суурь Түвшин (2006)	Хүрэх түвшин	
			2015	2020
1.1	Хоногт хэрэглэж буй жимс, хүнсний ногооны дундаж хэмжээ (нэгж)	3.2	3.6	4.0
1.2	Хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	72.5	60.0	50.0
1.3	Хоногт жимс огт хэрэглэдэггүй хүн амын эзлэх хувь	45.5	40.0	35.0
1.4	Гэрийн нөхцөлд хоол, хүнс бэлтгэхдээ өөхөн тос хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	7.2	5.0	3.0
1.5	Гэрийн нөхцөлд хоол, хүнс бэлтгэхдээ ургамлын тос хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	62.8	70.0	80.0
1.6	Давсны хэрэглээ (гр)	10.1	9.0	8.0
1.7	Илүүдэл жин ба таргалалттай хүн амын эзлэх хувь	31.6%	30.0	28.0
1.8	Таргалалттай хүн амын эзлэх хувь	9.8	9.3	8.8
1.9	Төвийн таргалалттай хүн амын эзлэх хувь	Эр 20.2 Эм 42.6	Эр 18.0 Эм 40.6	Эр 16.0 Эм 38.0
1.10	Хөдөлгөөний хомсдолтой хүн амын эзлэх хувь	23.1	20.0	18.0

1.11	Ажлын байранд идэвхтэй хөдөлгөөн хийж буй дундаж голч хугацаа (минут)	38.6	40.0	42.0
1.12	Ажилдаа ирж очиход зарцуулах хөдөлгөөний дундаж голч хугацаа (минут)	60	65	70
1.13	Чөлөөт цагаараа хийх хөдөлгөөний дундаж голч хугацаа (минут)	25.7	30	35

**ЗӨВ ХООПЛОХ, ДАСГАЛХӨДЛӨГӨӨНИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Эрүүл Мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 09 сарын 02-өдрийн 283/тот хамтарсан тушаалын хөёргүйгээр хавсралт



№	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хариуцах	Хамтран ажиллах	Хүпээгдэж буй үр дүн	Шалгуур үзүүлэлт
		байгууллага	байгууллага	байгууллага	байгууллага
1		2	3	4	5
					6

Нэгдүгээр зорилт: Зөв хооплох, дасгал хөдөлгөөнийг дэмжсэн орчин бүрдүүлнэ.

1.	Хүнсний бүтээгдэхүүний шошгын стандартыг шинэчлэн мөрдүүлэх	ХХААХҮЯ, ЭМЯ	МХЕГ, СХЗҮТ, ШУТИС НЭМХ-ХСТ	Хүнсний бүтээгдэхүүний орц, наирлага тодорхой болж хоолны зохицтой бүрдэнэ. Шошгыны хангасан бүтээгдэхүүний нэмэгдэнэ.	Шинэчилж, баталсан стандарт
2.	Шошгын стандартын шаардлагыг Уйлдвэрлэгчид, мэргэжлийн байгууллагуудад танилцуулах, сайжруулах, уулзалт, тогтолцоог тоог тогтолцоог тоог зохион байгуулах	ХХААХҮЯ, ЭМЯ	НЭМХ-ХСТ, СХЗҮТ, МХЕГ, ШУТИС	Хүнсний бүтээгдэхүүний орц, наирлага тодорхой болж хоолны зохицтой бүрдэнэ. Шошгыны хангасан бүтээгдэхүүний нэмэгдэнэ.	Уулзалт, сургалтад хамрагдсан хүний тоо
3.	“Эрүүл хүнс” лого нэвтрүүлэх журам боловсруулж мөрдүүлэх	ЭМЯ, ХХААХҮЯ	БОАЖЯ, МХЕГ, СХЗҮТ, НЭМХ-ХСТ, ШУТИС	Эрүүл хүнсний бүтээгдэхүүн байгууллагыг орчин бүрдэнэ.	Журам гарна батлагдан
4.	“Хоол зүйн зөвлөгөө” өгдөг төвүүдийг Магадлан итгэмжлэх болсовсруулах	ЭМЯ	НЭМХ-ХСТ, ЭМГ, МХЕГ	Хүн амд хоол зүйн зөвлөгөө үйлчилээний сайжирна.	Магадлан итгэмжлэгдсэн төвийн чанар тоо
5.	Хоол зүйн зөвлөгөө өгдөг магадлан итгэмжлэгдсэн төвүүдийг	ЭМЯ, НХХЯ	СЯ	Хоол зүйн зөвлөгөө өгдөг магадлан итгэмжлэгдсэн төвийн	Магадлан итгэмжлэгдсэн төвийн

мэндийн санхүүжүүлэх боломжийг судлах	даатгалын сангаас	төвшүд даатгалын санхүүжих	эрүүл сангаас боломж	мэндийн тоо
6. Орлогтоо багатай хүн амын бүлгийн хүнсний хэрэглээнд үнэлгээ өгч, шийдвэр гаргач наарт үнэлгээний дүнг танилцуулах уулзалтуудыг зохион байгуулах	НЭМХ-ХСТ	ЭМЯ, НХХЯ, СХЗҮТ, ШУТИС	Хоол, хүнсний байгууллагын оролцоо, хүнсний бүтээгдэхүүний чанар сайжирна.	Шалгарсан эрүүл хүнс үйлдвэрлэгчтүүн тоо
7. "Намрын ногоон өдрүүд" аян зохион байгуулж эрүүл хүнс үйлдвэрлэгч аж ахуйн НЭЖИЙГ урамшуулах	ХХААХУЯ, ЭМЯ	НЭМХ, ШУТИС, ХЭАХН, Хүнсчдийн холбоо	Хүнсний зохистой дасгал зан үйлтэй хүний тоо нэмэгдэнэ.	Батлагдсан "Ногоон жор"-ын тоо
8. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний түвшинд ХБӨ-НИЙ анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах "Ногоон жор" боловсруулж хэрэгжүүлэх	НЭМХ-ХСТ, БТСГ, ЭМГ	ЭМЯ	Хүнсний зохистой дасгал зан үйлтэй хүний тоо нэмэгдэнэ.	"Ногоон жор"-ын тоо
9. Эрүүл мэндийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээний түвшинд ХБӨ-НИЙ завсрын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах "Ногоон жор" боловсруулж хэрэгжүүлэх	НЭМХ-ХСТ, БТСГ, ЭМГ	ЭМЯ	Хүнсний зохистой дасгал тусламжтайгаар ХБӨ-тэй тэмцэх, сэргийлэх хүний тоо нэмэгдэнэ.	Батлагдсан "Ногоон жор"-ын тоо
10. Хоёрдогч хүндрэлээс сэргийлэх, нөхөн сэргээх "Ногоон жор"-ыг боловсруулж хэрэгжүүлэх	НЭМХ-ХСТ, БТСГ ЭМГ	ЭМЯ	Хүнсний зохистой дасгал хэрэглээ, хөдөлгөөний тусламжтайгаар архаг ёвчтэй хүмүүсийн нөхөн сэргэлт сэргэлтийн сайжран ёвчлэлийн дахилт цөөрөх боломж нэмэгдэнэ.	"Ногоон жор"-ын тоо
11. Мэдээлэл, харилцаа холбооны "Unite" ХХК-г "Ногоон жор" хөдөлгөөнтэй холбон хамтран ажиллах	НЭМХ, БТСГ	ЭМЯ, Хувийн хэвшил, Бизнесийн байгууллага	"Ногоон жор" хөдөлгөөнд хувийн хэвшил, бизнесийн байгууллагуудыг оропдоо сайжирч, байгууллагын	"Ногоон жор" хөдөлгөөнийг хэрэгжүүлсэн байгууллагуудын тоо.

12.	Зонхилтон өвчнөөр хэрэгцээ, хүнсний удирдамжий боловсруулах	тохиолдох өвчилсөн тодорхойлоход байгууллагын нэмэгдүүлэх	халдварт шадарлагад Эрүүл мэндийн оролцоо, манлайллыг	бус хүмүүсийн нийцсэн хэрэглээний шинэчлэн	НЭМХ-ХСТ НЭМХ-ХСТ ХХААХУЯ, СХЗҮТ, ШУТИС
13.	Хүнсний шиимт тодорхойлоход байгууллагын нэмэгдүүлэх	бодисын Эрүүл мэндийн зах,	иичлэг, найрлагыг мэндийн дэлгүүр ажиллуулах хөдөлгөөнийг хөгжүүлэх	ЭМЯ, НЭМХ-ХСТ ЭМГ	ДЭМБ, НЭМХ, Хүнсдийн холбоо
14.	Барилга хот телевлөгөөнд тапбай шаардлагыг	биеийн тамир, спортын тогтоосон баримт	зураг чанарын бичгийг боловсруулах	ЗТБХБЯ, ЭМЯ	ХХААХУЯ, СХЗҮТ, НБТСГ
15.	Хүн ам болон иргэд зорчих төгрөгийн түүний чанарын бүрдэнэ.	Хүн ам боловсруулах	биеийн тамир, спортын стандарт саижкрайх нөхчөл бүрдэнэ.	Биеийн тапбайн болов чанарын стандарт саижкрайх нөхчөл бүрдэнэ.	Хүн ам боловсруулах тамир, спортын стандарттай болно.
16.	Хүн ам болон иргэд дугуй зорчих таатай орчин бүрдүүлэх	ЭМЯ, БТСГ, Аймаг, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ, харьяа агентлагууд	Хүн ам болон бэрхшээлтэй болов тэргэнцэрээр таатай орчин бүрдэнэ.	Хүн ам болов бэрхшээлтэй иргэд дугуй зорчих тэргэнцэрээр таатай орчин бүрдэнэ.	Хүн ам болов бэрхшээлтэй дугуй зорчих тэргэнцэрээр зарчмын төхөн
17.	Аймаг, нийслэл, биеийн тамир, орчин бүхий тоог нэмэгдүүлэх	ЗТБХБЯ ЭМЯ	Аймаг, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ, харьяа агентлагууд	Аймаг, НИЙСЛЭЛ, СУМ, НИЙТИЙН биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдэнэ.	Хүн ам болов бэрхшээлтэй иргэд дугуй зорчих тэргэнцэрээр зарчмын төхөн
18.	Төрийн байгууллага, тойрны тэргэнцэрээр	терийн бус ЗДТГ	Орон нутгийн газарт дугуй,	Тохиолулсан Цэцэрлэгт хүрээлэнгийн тоо	Төрийн байгууллага дугуй, тэргэнцэр, зарчмын төхөн

	аюулгүй орчин бурдүүлэх					нөхцөл бурдүүлсэн
19.	Сууч өмчлөгчдийн холбоогий хамгтран биеийн спортыг дэмжигч СӨХ шалгаруулах болзолт урапдааныг зарлах	БТСГ Сууч өмчлөгчдийн үндэсний холбоо	Аймаг, нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Иргэд биеийн тамираар хичээллэн эрүүл мэндээ бэхжүүлэх нөхцөл сайжирч орчин бурдэнэ.	Биеийн спортыг СӨХ-ийн тоо	тамир, дэмжигч
20.	Нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх болон сэргээн барьж байгуулж буй аж ахуйн нэгийн тухайн үйл ажиллагааг төрөөс хөнгөлөлтэй татвар, зээлийн бодлогоор дэмжих	ЭМЯ, ТЕГ БТСГ, НБТХ	ХЗДХЯ, барьж барилгын тоо Үйлчилгээний хүргээмж	Шинээр болов сэргээн барьж тоо нэмэгдэж үйлчилгээний хүргээмж сайжирна.	Шаардлага спортын тоо	хангасан барилгын тоо
21.	Биеийн тамирын багаж, хэрэгслийг үйлдвэрлэх дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх	БТСГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Хүн ам биеийн тамираар хичээллэх сайжирна.	Үйлдвэрийн тоо	
22.	Спортын бараа бүтээгдэхүүний чанарын стандартыг боловсруулах	ЭМЯ, БТСГ	СХЗҮТ, МХЕГ, НБТСГ	Спортын бүтээгдэхүүний чанар	Бараа бараа бүтээгдэхүүний чанарын стандарттай болно.	
23.	Байгууллага, сургууль, орон сууцны гадаа ил талбайд байрлах багаж хэрэгслийн стандарт гарах	НЭМХ, БТСГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд, СӨХ	Хүн ам биеийн тамираар хичээллэх сайжирна.	Батлагдсан стандарттай болно.	
24.	Өвлийн улиралд нийтийг хамарсан биеийн тамир, спортын үйлчилгээний нийтлэг дагаж мөрдөх стандартыг боловсруулах	ЭМЯ, БТСГ	МХЕГ, СХЗҮТ, НБТСГ	Хүн ам өвлийн улиралд нийтийн биеийн спортоор хичээллэх орчны нөхцөл сайжирна.	Стандартад нийцсэн үйлчилгээний байгууллагын тоо	
25.	Бие баялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах, зөвлөгөөг ех төрийн бус байгууллагуудыг байгуулах үйл ажиллагааг дэмжих,	ЭМЯ, БТСГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Бие баялдрын хөгжил, чийрэгжилтийн тогтоох сорил авах, зөвлөгөөг ех ТББ-ын тоо	Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ТББ-ын тоо	

26.	Нийтийн биейн тамир, нийтлэг спортын төрлүүдийг хөгжүүлэхэд салбарын яам, байгууллагын оролцоог сайжруулан биейн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх компанийт ажил зохиох	ЭМЯ, БТСГ	Бусад салбарын яамд	Нийтийн биейн тамир, спортын хэмжээ төрлүүдийг хөгжүүлэхэд яам, оролцоо	Нийтийн биейн тамир, спортын хэмжээ зохион байгуулж буй яамдын тоо	Мэдлэг, чадвар, оролцоо сайжирна.	Мэдлэг, чадвар, оролцоо сайжирна.
27.	Аж ахуйн нэгж, байгууллагад биейн тамирын хамтлаг, чийрэгжүүлэх танхим байгуулах, нийтийн биежийн тамираар хичээллэх хөдөлгөөнийг өрнүүлэх	БТСГ	Аймаг, Нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Биеийн тамирын агаажийн нэгжийн сайжирна.	Биеийн тамирын агаажийн нэгжээнд аж ахуйн оролцоо	Байгуулагдсан спортын хамтлагийн сайжирна.	Байгуулагдсан спортын хамтлагийн сайжирна.
28.	Зохистой холболттой холбогдох асуудлаар импортлогч, үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгуулгүүдтэй уулзалт зохион байгуулах	ЭМЯ НЭМХ	ЭМГ, бусад холбоо, нийгэмлэг	Хоол тэжээлийн чанарын асуудал сайжрах нөхцөл бүрдэнэ.	Хоол тэжээлийн чанарын зохиогдсон уулзалтын тоо	Хэвлэл мэдээлээр сурталчилсан тоо	Хэвлэл мэдээлээр сурталчилсан тоо
29.	6 сар хүртэлх хүүхдийг эхийн сүүгээр дагнан хоолпох зан үйлийг төлөвшүүлэх сургалчилгааны материал боловсруулан тогтолцуталчилах	НЭМХ, ЭМГ	ЭНЭШТ	Хүүхдийг эхийн сүүгээр зөв хоолпох мэдлэг, дадал сайжирна	Хүүхдийг эхийн сүүгээр зөв хоолпох мэдлэг, дадал сайжирна	Хэвлэл мэдээлээр сурталчилсан тоо	Хэвлэл мэдээлээр сурталчилсан тоо
30.	Бүх шатны боловсролын эмч, НЭМХ-ХСТ, БТСГ стандартыг шинэчилэх	ХААХҮЯ, МХЕГ, СХЗҮТ, ШУТИС	ЕБС-ын сурагчид зорул, аюулыгүй орчинд сурагч боловсрох нөхцөл бүрдэнэ	Нийтийн цайны газар, биежийн тамирын заал, ил талбайн стандартын тоо	Нийтийн цайны газар, биежийн тамирын заал, ил талбайн стандартын тоо	Оюутан сурагчид аюулыгүй, цэвэр орчинд биежийн тамир, спортоор хичээллэх биежийн нөхцөл сайжирна.	Оюутан сурагчид аюулыгүй, цэвэр орчинд биежийн тамир, спортоор хичээллэх биежийн нөхцөл сайжирна.
31.	Бүх шатны сургуулийн дотуур байранд болон байрны гадна талд биежийн тамирын дасгал хийх танхим, талбай байгуулж, байнга ажиллах нөхцлийг бурдүүлэх	ЭМЯ, Оюутны спортын холбоо	БСШУЯ,	Дотуур байр, байрны гадна талд байгуулсан тамир, спортоор хичээллэх дасгал хийх танхим, талбайн тоо	Дотуур байр, байрны гадна талд байгуулсан тамир, спортоор хичээллэх дасгал хийх танхим, талбайн тоо	Дотуур байр, байрны гадна талд байгуулсан тамир, спортоор хичээллэх дасгал хийх танхим, талбайн тоо	Дотуур байр, байрны гадна талд байгуулсан тамир, спортоор хичээллэх дасгал хийх танхим, талбайн тоо
32.	ЕБС-ийн "Биежийн тамир-эрүүл мэнд", БСШУЯ	ЭМЯ, БТСГ,	"Биежийн тамир-эрүүл мэнд", БСШУЯ	Шинэчилсэн сурх	Шинэчилсэн сурх		

Хоёрдугаар зорилт: Зөв хоолпох, дасгал хөдөлгөөний тусламжтайгаар эрүүл аж төрөх хэв маягийг хүүхэд ахуй нааснаас эхлэн төлөвшүүлж, хүн амын өдөр тутмын хэрэглэгээ болгоно.

“Эрүүл мэнд” хичээлийн агуулга, стандарт, сурх бичгийг шинэчлэн хүнсний зохицой хэрэглээ, дасгал хөдөлгөөний талаар нэмж оруулах		НЭМХ, ЭМГ, СХЗҮТ, ОУБ, ТББ	мэнд”, “Эрүүл хичээлийн шинэчлсэн агуулга, стандарт, сурх бичгий, хэрэгжих таатай орчин бурдэнэ.	мэнд”, “Эрүүл хичээлийн шинэчлсэн мэнд” бичгийн тоо	
33. “Эрүүл мэнд”-ийн хичээлийн загвар кабинет, Биений тамирын загвар заал байгуулж үйл ажиллагааг нь сурталчилах	ЭМЯ, ЭМГ, БТСГ	НЭМХ, ДЭМБ, Нийслэлийн БТСГ, БГ, ЭМГ	Олон улсын жишит нийцэн кабинет, заал танхим бий болно	Олон улсын жишит нийцэн кабинет, заал танхилтай бопсон	
34. ЕБС-ийн “Үдийн цай” хөтөлбөрийн хоол, хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдалд үнэлгээ өгөх судалгаа хийж, зөвлөмж боловсруулах	ЭМЯ	БСШУЯ, МХЕГ, НЭМХ	“Үдийн цай” хөтөлбөрийн хоол, хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдал тогтоогдож сайжруулах зөвлөмж гарч арга зам тогтоогдоно	ЕБС-ийн “Үдийн цай” хөтөлбөрийн өвчлөлийн тоо буурна	
35. Бүх шатны боловсролын байгууллагын хоолны газар, хүнсний цэгүүдийн багаж тоног төхөөрөмж, үйл ажиллагааны өнөөгийн байдалд үнэлгээ өгөх	НЭМХ, МХЕГ, БСШУЯ	ЭМЯ, ХХААХУЯ	Тоног төхөөрөмжийн шинчлэл, шинэ технологи, үйл ажиллагааг сайжруулах боломж бий болно	Цаашид хэрэгжүүлэх хэмжээний төлөвлөгөө гарна	авч арга
36. “Үдийн цай” хөтөлбөрийн хоол, хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдлын чанарыг сайжруулах салбар дундын хамтарсан зөвлөгөөний зохион байгуулж, тодорхой асуудлаар Засгийн газрын шийдвэр гаргах	ЭМЯ, ХХААХУЯ	МХЕГ, БСШУЯ, НЭМХ	Холбогдох салбарын ажиллагаа сайжирна.	Засгийн газрын тогтоол, шийдвэр	
37. Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний одоогийн байдалд үнэлгээ өгөх	ХХААХУЯ	МХЕГ, НЭМХ	Үнэлгээний тайлан гарна.	Цашид хэрэгжүүлэх хэмжээний төлөвлөгөө гарна.	авч арга
38. Бүх шатны боловсролын байгууллагын хоолны газар, хүнсний цэгүүдийн багаж төхөөрөмжийн стандартыг шинчлээн боловсруулж, салбар дундын уулзалт зохион	ЭМЯ, БСШУЯ, СХЗҮТ	ХХААХУЯ, МХЕГ, ХЭАХН, Холбогдох ТББ-үүд	Хоолны газар, хүнсний цэгүүдийн эрүүл аюулгүй байдал сайжирна.	Шинэчлэн стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	

39.	байгуулж, мөрдүүлэх ажил зохиц Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг заах сургагч багш бэлтгэн эрх олгох	ЭМЯ, БТСГ, ЭМГ,	БСШУЯ, ШУТИС, НЭМХ	Хүнсний зохистой хэрэглээ, идэвхтэй хөдөлгөөнийг заах бэлтгэгдсэн хүний нөөцтэй болно.	Сургагч багшийн эрх авсан мэргэжилтнүүдийн тоо
40.	Сургууль, цэцэрлэгийн ундын усны аюулгүй байдал, хангамжийг сайжруулах	БСШУЯ	ЭМЯ, МХЕГ, НЭМХ	Ундын цэвэр хангадсан сургууль, цэцэрлэгтэй болно.	Ундын цэвэр усаар хангадсан сургууль, цэцэрлэгийн тоо
41.	Оюутан, сургачдын чөлөөт цаг, хичээлийн бус цагаар бие бялдрыг нь чирэгжүүлэх, биийн тамираар хичээллүүлэх	ЭМЯ, БТСГ	БСШУЯ, СЯ	Чөлөөт цаг, хичээлийн бус цагаар бие бялдрыг нь хөгжүүлэх ажлын чанар сайжирна.	Удирдамж гарна
42.	ЕБС-ийн биийн тамирын багш нарын спортын секц, дугуйлан ажилтууллах, гүнзтийрүүлсэн сургалттай анти буллаг нээн удирдах, биийн тамирын тэмцээн уралдаанд баг тамирчдыг оролцуулсан тохиолдолд эдийн засгийн урамшуулалт олгох журам гаргаж мөрдүүлэх	ЭМЯ, БТСГ	БСШУЯ, СЯ	Оюутан, сургачдын чөлөөт цаг, хичээлийн бус цагаар бие бялдрыг нь хөгжүүлэх биийн тамираар хичээллэгсдийн тоо нэмэгдэнэ	Журам гарна
43.	Сурагчдын дунд "Ногоон жор" булгийг байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах	БСШУЯ	ЭМЯ, БТСГ, ЭМГ, НЭМХ	"Ногоон жор" бүлгээмд оролцсон сургачдын мэдлэг, оролцоо сайжирна.	ЕБС-ын "Ногоон жор" булгийн тоо.
44.	ЕБС-ийн нийгмийн ажилтан, эмч, хоол уйлдвэрлэл явуулж байгаа баг, эзэг эхийн зөвлөл, биийн тамирын багш, эрүүл мэнд хичээлийн багш наарт арга зүйн сургалт явууллах	ЭМГ, БТСГ, НЭМХ	БСШУЯ, ЭМШУИС	ЕБС-ийн ажиллагсдын хандлага нэмэгдэнэ.	Багш, Зохион байгуулсан сургалтын тоо
45.	Биийн тамирын заал, танхим, гадна талбайн ашиглалтыг сайжруулах, шинэчлэх арга хэмжээ зохиох	ЭМЯ, БТСГ	БСШУЯ, СЯ	Биийн тамираар хичээллэх орчны нөхцөл сайжирна.	Шинэчилсэн, зассан заал талбайн тоо
46.	Бүх шатны боловсролын байгууллагын биийн тамирын	ЭМЯ, БТСГ	БСШУЯ, БТДС	Бие бялдрын хөгжлийн түвшинг үнэлэх, хяналт хичээлийн агуулгад	Биийн тамирын

хичээлийн сургалтын агуулгад бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилыг оруулах, биений тамирын багш нарын ажлын үзүүлэлтийн нэг болгох				тавих, багш нарын ажлыг дүгнэн сайжруулах нөхцөл бүрдэнэ.		бие хөгжлийн сорил авах тест орсон байна.	
47. Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндэд сөргөөр нөөөлж буй хүнсний бүтээгдэхүүний жагсаалт гаргаж, худалдах үйл явцыг зогсох хамгарсан журам боловсруулах	ЭМЯ, ХХААХУЯ	ЭМГ, МХЕГ, НЭМХ-ХСТ	Хүүхэд, өсвөр үенийхний эрүүл бус хүнсний бүтээгдэхүүний хэрэгтээ буураа.	Хүүхэд, өсвөр үенийхний эрүүл бус хүнсний бүтээгдэхүүний хэрэгтээ буураа.	Хамгарсан журам батлагдан гарна.		
48. Бие бялдрыг хөгжүүлэх, хүнсний зохицтой хэрэгтээ, дасгал хөдөлгөөнеэр илүүдэл таргалалтын тархалтыг бууруулах, жингээ тогтол барих загвар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж буй байгууллага, иргэдэд арга зүйн зөвлөгөө ёгех	БТСГ ЭМГ НЭМХ	Аймаг, нийспэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Загвар хөтөлбөр буй хэрэгжүүлж байгууллагуудын ажиллагааны сайжруулна.	Загвар хөтөлбөр буй хэрэгжүүлж байгууллагад чанар үйл зөвлөгөөний тоо	Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлсэн байгууллагад өгсөн зөвлөгөөний тоо		
49. Идэвхтэй, үр дүнтэй ажиллаж буй ажиллагааг батламжлан сурталчилан таниулах	ЭМЯ ХХААХУЯ	ЭМГ БТСГ НЭМХ	ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ИДЭВХЖИН ХҮН АМЫН ХАМРАГДАЛТ САЙЖИРНА.	ТББ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БАТЛАМЖИЛСАН БУСАД АЖ АХҮЙН НЭТЖИЙН ТОО			
50. Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд биений тамирын хамтлаг, чийрэгжүүлэх танхим байгуулах, нийтийн биений тамиираар хичээллэх хөдөлгөөний өрнүүлэх	БТСГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Биений тамирын арга хэмжээнд аж ахуйн нэгжийн оролцоо сайжирна.	Байгуулагдсан спортын хамтлагийн тоо			
51. Зөв хооплох, дасгал хөдөлгөөнийг дэмжих аливаа хөтөлбөр, төсөл, биений жингээ хэвийн хэмжээнд барих, хяналт тавих зорилго бүхий "Жин хасах тэмцээн, хамгийн их жин хасагч" гэх мэт арга, аргачилын санаал санаачлагыг дэмжин урамшуулах	ЭМГ БТСГ НЭМХ	Олон нийтийн телевиз ТББ-Д	Хүн амын дундах бие бялдрын чийрэгжилт намадэж, илүүдэл жинтэй хүмүүсийн тоо буураа.	Нийтийг хамарсан хөгжөөнт нэвтрүүлгийн тоо			

Гуравдугаар зорилт: Хувь хүнд зөв зан үйл, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны чанар, хүртээмжийг сайжруулна.

52.	Хүнсний зохицтой хэрэглээний "Гэр" зөвлөмж"-ийг боловсруулж, ашиглах заавар бүхий гарын авлага боловсруулж хэвлүүлэх, түгээх	НЭМХ	ЭМГ	Мэргэжлийн мэдлэг, арга барил сайжирч сурталчилгааны материалын хангамж сайжирна.	Сурталчилгааны материалын тоо ширхэг
53.	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хоол, хүнсний "Нэгж порц"-д агуулагдах илчлэг, шимт бодисын хэмжээг тооцон бэлтгэх гарын авлага боловсруулах, түгээх	НЭМХ	ЭМГ, ШУТИС, Хүнсчдийн холбоо	Мэргэжлийн ажилтын мэдлэг, арга барил сайжирч хүн ам "Нэгж порц" тооцон хооллох нөхцөл бүрдэнэ.	Гарын хэвлэгдэн гарсан байна.
54.	"Эрүүл хоолны жор" боловсруулж, хэвлүүлэх, түгээх	НЭМХ	ЭМГ, ШУТИС, Хүнсчдийн холбоо	Хүн ам зохицтой хооллох мэдлэг, арга барил сайжирна.	Эрүүл хоолны жор гарна.
55.	Хүн бүр гэр, ажлын байранд, чөлөөт цагаараа идэвхтэй дасгал хийх хотолбөрүүдийг боловсруулж хэвлүүлэх, түгээх	БТСГ	ЭМГ, БТДС Аймаг, Нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Хүн амьн дасгал хөдлөгэн сайжрах нөхцөл бүрдэнэ.	Хүн ам хэрэгцээнд биесийн тамирын дасгал хөдлөгөөний хөтөлбөртэй гарна.
56.	Өөх тос, сахар, давсны зохицтой хэрэгтэй, биеийн жинг хянах аргын талаар хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааны гарын авлага, сурталчилгааны материал боловсруулан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтолц сурталчилгах	НЭМХ БТСГ	ЭМГ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Хүн ам зохицтой хооллох дасгал хөдөлгөөн хийх ач холбогдоыг ойлгон хэвшүүлэх хандлага сайжирна.	Хэвлэл, мэдээллийн сурталчилгаа тогтол гарсан байна.
57.	Хэвлэл мэдээлэл, радио, телевизийн хотолбөрт хүнсний зохицтой хэрэгтэй, дасгал хөдөлгөөний талаар эзлэх мэдээллийн хувь, хүргэх мэдээ мэдээллийн төрөл, хэлбэрэйг нэмэгдүүлэх	БТСГ ЭМГ НЭМХ	Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд	Хүн амд хүргэж буй сайжирна.	Нэг одрийн нийт хөтөлбөрт хүнсний зохицтой хэрэгтэй, дасгал хөдөлгөөний талаар мэдээллийн хувь нэмэгдэнэ.
58.	Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг	БТСГ	Холбогдох	Хүн амьн мэдлэг, хандлага,	Хөгжөөнт, цэнгээнт

	Дэмжих олон нийтэд сурталчилсан уралдаан, хөгжөөнт, цэнгээнт нэвтрүүлгийн тоо, чанарыг нэмэгдүүлэх	ЭМГ НЭМХ	терийн болон төрийн бус байгууллагууд	оролцоо сайжирна.	нэвтрүүлгийн тоо.
59.	Бие бялдрын соёлтой, дасгал хөдөлгөөнийг бүл, хамт олныг дэмжиж, улс, аймаг, нийслэлийн нэрэмжит шагнал бий болгох	БТСГ, Аймаг, Нийспэлэйн ЗДТГ	ЭМЯ, ЭМГ	Бие бялдрын соёлтой, дасгал хөдөлгөөнийг эрхэмлэсэн зан үйл, аж төрөх арга барилтай хувь хүн, гэр бүл, хамт олны оропдоо сайжирна.	Бие бялдрын соёлтой, дасгал хөдөлгөөнийг эрхэмлэсэн зан үйл, аж төрөх арга барилтай хувь хүн, гэр бүл, хамт олны тоо
60.	“30 минут өөртөө зарцуулья”, өдөрт 10 000 алхам алхая болон аэробик, нийтийн бужиг, явган аялал, гүйтт, хийн болон иогийн дасгал зэрэг бүх нийтийг хамарсан хөдөлгөөнийг өргөжүүлэх	БТСГ, ЭМГ	ЭМЯ	Идвэхтэй хөдөлгөөний талаар хүн амын мэдлэг, дадал сайжирна.	Бүх хөдөлгөөн зохион байгуулсан тоо.
61.	Хоол.tn, mongoliantransport.mn сайтын Уйл ажиллагааг тогтолцожуулж, олон нийтэд сургалчиллах	БТСГ, НЭМХ	ХХААХҮЯ, ЭМГ, ШУТИС	Эруул аж төрөх мэдлэг, арга барил боломж нэмэгдэнэ.	Хоол.tn, mongoliantransport.mn сайтын Уйл ажиллагаа тогтолжин.
62.	Хоол судлаач, эмчилгээний хоол зүйч, чиирэгжилт, биелүүн тамирын багш, арга зүйч, эмч, ажилтны хүнсний зохицтой хэрэглээ, дасгал хөдөлгөөний талаарх мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	ЭМЯ, БТСГ, НЭМХ-ХСТ	Өрх, сүм, дүүргийн эруул Мэндийн төв	Эмч, мэргэжилтэний мэдлэг мэдээлэл сайжирч улмаар хүн амын эруул Мэндийн мэдлэг болсовсрол дээшилнэ.	Зохион байгуулсан сургалтын тоо
63.	Эрүүл мэнд, биелүүн тамир, спорт, хоол тэжээл, хүнсний мэргэжилтэнд зориуулсан “Хүнсний зохицтой хэрэглээ, дасгал хөдөлгөөн” арга зүйн удирдамж боловсруулах, хэвлүүлэх	ЭМЯ, БТСГ, НЭМХ-ХСТ	Олон улсын байгууллагууд	Эрүүл мэнд, биелүүн тамир, спорт, хоол тэжээл, хүнсний мэргэжилтэний мэдлэг, ур чадвар сайжрах нэхцэл бүрдэнэ.	“Хүнсний зохицтой хэрэглээ, дасгал хөдөлгөөн” гарын авлагын хэвлэгдсэн тоо
64.	Олон нийтэд “Имлэсэн эрүүл мэндийн	ЭМЯ	Олон улсын	Орон нутаг, байгууллагын	Мэдээлэл,

				Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад олон улсын түвшинд зөвшөөрөгдсөн, нотолгоонд сууринсан гарын авлага, ном, материалыар хангах	НЭМХ-ХСТ, БТСГ	байгууллагууд	хүрэнд явуулах мэдээлэл сурталчилгааны материаллаг сайжирна.	сурталчилгааны материалын тоо
65.	Эрүүл Биений төвийн багаж, сайжруулах	мэндийн тамир, сургалт хэрэгслийн	байгууллагудын чийрэгжилтийн сургалчилгааны хангамжийг	ЭМЯ, БТСГ	Сум, дүүргийн эрүүл мэндийн газар	Орон байгууллагууд багаж тоног техөөрөмжөөр хангагдана.	Хуваарилсан тоног техөөрөмжийн тоо	
66.	Эрүүл мэндийн салбарт хэрэглэгдэж байгаа хүнсний зохицой хэрэглээг дэмжсэн багаж хангамжид үнэлгээ хийж, цаашдын ханган нийлүүлэх боловсруулах	нийтийн биений тоног хангамжид үнэлгээ хийж, цаашдын ханган нийлүүлэх төлөвлөгөө	ЭМЯ, НЭМХ-ХСТ, БТСГ	Олон улсын байгуул лагууд	Хүнсний хэрэглээний багаж тоног техөөрөмжийн одоогийн байдалд үнэлгээ хийгдэнэ.	Шаардлагатай тоног техөөрөмжийн жагсаалт хангамжийн нэгдсэн төлөвлөгөө гарна.		
67.	Үйлчилүүлэгчийн байдалд цогц үнэлгээ өгөх зориулалт бүхий биений бүтцийг тодорхойлогч багажаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх байгууллагуудыг хангах	хоол тэжээлийн шатны тусламж үзүүлэх	НЭМХ-ХСТ	ДЭМБ, НҮБ-ын ХС	Анхан шатны эрүүл мэндийн тусламжийн байгууллагад хүн амын хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгөх бүрдэнэ.	“Тапіта” хангагдсан мэндийн анхан шатны байгууллагуудын тоо		
68.	Илч зарцуулалт хэмжигч багажаар хоёрдогч шатны эрүүл мэндийн байгууллагуудыг хангах	байгууллагууд	НЭМХ-ХСТ	ДЭМБ, НҮБ-ын ХС	Хүн амын зохицой хоол тэжээлийн мэдлэг, дадал хэвшиэн.	Илч зарцуулалт хэмжигч багажаар хангагдсан		
69.	Халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулах, эрүүл аж төрөх ага барилыг сурталчилсан компанийт ага хэмжээг зохион байгуулах	ЭМЯ, ЭМГ, БТСГ	НЭМХ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Хүн амд зөв зан үйлтэй болох, эрүүл аж төрөх талаарх сургалчилгааны хүртээмж сайжирна.	Компанит ажлын загвартай болно.	байгууллагуудын тоо		
70.	Зөв хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэмэгдүүлэх,	БТСГ, ЭМГ, НЭМХ	Холбогдох төрийн бус байгууллага	Хэвлэл байгууллагын сайжирна.	Мэдээллийн оролцоо	Хэвлэл, мэдээлэлийн хэрэгслээр гарч байгаа мэдээний тоо		

71.	Урамшиулалт ажилт зохиох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, бүгэц, найрлага, шинэ технологи, биеийн тамирын шинэ мэдээ мэдээлэл бүхий олон нийтэд зориулсан кино, нэвтрүүлэг хийх, сэтгүүл гарган сургалчилах	БТСГ, НЭМХ	ЭМЯ, ХААХҮЯ, ШУТИС, Холбогдох төрийн бус байгууллага	Хүнсний шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн Уйлдвэрлэх, шинэ технологийн талаарх мэдээллийн хүртээмж сайжирна.	Олон зориулсан нэвтрүүлэг, сэтгүүлийн тоо
72.	Зөв хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих эрх зүйн болон материаллаг орчин бурдуулэх талаар нийтийн бүхий л салбарын шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, бизнес, Уйлдвэрлэгчдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх ухуулга, сургалчилгааны сургалт, уулзалт зохион байгуулах	ЭМЯ, ЭМГ	БТСГ, НЭМХ Бизнес, Уйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо	Бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо сайжирна.	Хамтын ажиллагаа сайжирна. Уулзалтын тоо

Дөрөвдүгээр зорилт: Зөв хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих тандалтын тогтолцоог бэхжүүлнэ.

73.	Зөв хоолпох, дасгал хөдөлгөөний чиглэлээр сургалт, судалгааны үндэсний баг байгуулах	ЭМЯ	Холбогдох байгууллагууд	Үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалт, ажлын уялдаа холбоо сайжирна	Сайдын тушаал
74.	НЭМХ-ийн ХСТ-ийн дэргэд "Шим тэжээл судалалын лаборатори" байгуулах	ЭМЯ, НЭМХ-ХСТ	Олон улсын байгууллагууд	Хүнсний тэжээлэлтийн үзүүлэлтийг хянах чадамж сайжирна	Шим судалын тэжээл
75.	Зөв хоолпох, дасгал хөдөлгөөнийг дэмжих үндэсний стратеги, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	ЭМЯ, БТСГ, НЭМХ	Холбогдох байгууллагууд	Стратегийн хэрэгжилт эрчимжинэ.	ХШУ хийсэн ажлын тоо
76.	Амьдралын хэв маяг, зан үйлийг өөрчлөлттэй холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга барилд сургах зорилгоор	Олон улсын байгууллагууд	Үндэсний мэргэжилтний сайдирна.	Сургагдсан хүний тоо	

олон улсын зөвлөх урьж ажиллуулан судалгааны багийн сургах				
77. Нийтийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний одоогийн байдалд үнэлгээ өгч зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх	НЭМХ	ШУТИС, ХХАДХҮЯ, МХЕГ	Хоол цай, биетийн тамирын үйлчилгээний байгууллагуудыг хөгжүүлэх цаашдын тогтоогдоно.	Гарсан үнэлгээ, зөвлөмжийн тоо
78. Нийтийн хоолны байгууллагуудын байр, тоног төхөөрөмж, материал хангамжийн хяналтыг тогтмолжуулах	МХЕГ	ЭМЯ, ХХАДХҮЯ, ШУТИС	Хүн амын хэрэгцэнд нийцэн орчинд чанартай үйлчилгээ явагдах нөхцөл бүрдэнэ.	Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тоо
79. Хүнсний бүтээгдэхүүний итчлэг, шимт бодисын үндэсний лабораторийг байгуулах	ЭМЯ, ХХАДХҮЯ, НЭМХ-ХСТ	БОЖЯ, МХЕГ, СХҮТ, ШУТИС	Хүнсний бүтээгдэхүүний итчлэг, шимт бодисын найрлагыг тодорхойлох, хянах оношлогоо чадамж сайжирна.	Хүнсний бүтээгдэхүүний итчлэг, шимт бодисын үндэсний лабораторын тоо
80. Биетийн тамирийн үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд үнэлгээ өгч зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх	БТСГ	МХЕГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, харьяа агентлагууд	Хоол цай, биетийн тамирийн үйлчилгээний байгууллагуудыг хөгжүүлэх цаашдын тогтоогдоно.	Гарсан үнэлгээ, зөвлөмжийн тоо
81. Биетийн тамирийн байгууллагуудын байр, тоног төхөөрөмж, материал хангамжийн хяналтыг тогтмолжуулах	БТСГ	МХЕГ	Хүн амын хэрэгцээнд нийцэн орчинд чанартай үйлчилгээ явагдах нөхцөл бүрдэнэ.	Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тоо